



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/452

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн зээлийн
санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Хууль зүйн сайдын “Суралцуулах тухай” 2014 оны А/77 дугаар тушаал, 2014 оны 1/4279 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батболд овогтой Галбадрахыг ОХУ-ын Омск хотын Дотоод хэргийн яамны харъяа академид эрх зүйн чиглэлээр адьюнктурт 3 жил, Даваасамбуу овогтой Санзоригийг ОХУ-ын Москва хотын Дотоод хэргийн яамны Удирдлагын академид эрх зүйн чиглэлээр адьюнктурт 3 жил 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн Сургалтын Төрийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцуулсугай.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР